

Монгол Улсын хүн ам 1996 онд

Одгэрэл УСГ-ийн мэргэжилтэн

Монгол Улсын Их Хурлаас 1996 оны 4 дүгээр сард баталсан “Монгол Улсын төрөөс баримтлах Хүн амын бодлого”-ыг хэрэгжүүлж байгаа нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг зорьж байгаа, цөөн хүн амтай, өргөн уудам нутагтай, хүн амын нягтрал бага, насны бүтэц залуу, нүүдлийн болон суурин иргэншил хосолсон манай орны хувьд хүн амын талаар явуулж байгаа томоохон арга хэмжээ юм.

Хүн амын тоо, түүний өсөлт

Монгол Улсын иргэд, цагаач гадаадын иргэдээр тооцоход хүн амын тоо 2347.1 мянга болж өмнөх оноос 34.3 мянган хүнээр буюу 1.5 хувиар нэмэгдлээ. Хүн амын 49.6 хувь нь эрэгтэйчүүд, 50.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Хот, суурингийн хүн ам өмнөх оноос 2.0 хувиар, хөдөөгийн хүн ам 1.1 хувиар тус тус өсөв. Хотын хүн амын өсөлт нь хүн амын өсөлтөөс өндөр байгаа нь хөдөөнөөс хот уруу шилжих хөдөлгөөн ихсэж байгаатай холбоотой. 1990 оноос хүн амын өсөлтийн түвшин буурч 1996 онд 1.5 болов. Манай улсын хүн амын өсөлтийн хурдыг бууруулахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь төрөлтийн бууралт юм. Гэсэн хэдий ч Монголын хүн амын тооны өсөлт ирээдүйд үргэлжилнэ.


1996 оны эцсийн байдлаар хамгийн олон хүн амтай эхний 5 аймгийг жагсаавал:

Аймгийн нэр	мян.хүн
Хөвсгөл	121.3
Өвөрхангай	113.8
Төв	112.3
Завхан	106.5
Сэлэнгэ	104.3


1996 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 517.7 мянган өрх байгаагаас 254.1 мянга нь хөдөөд, 171.0 мянга нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хотод, 92.6 мянга нь аймгийн төв болон суурин газарт оршин сууж байна. Нэг өрхөд ногдох хүний дундаж тоо 4.5 болов. Өнгөрсөн оноос нийт өрхийн тоо 3.6 мянга, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойрын өрх 4.0 мянга, хөдөөд 8.0 мянгаар тус тус нэмэгдэв.

Хүн амын насны бүтцийг авч үзвэл 37.3 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 58.9 хувь нь 15-64 насны хүн ам, 3.8 хувь нь 65 түүнээс дээш насны хүн ам эзэлж байгаа нь манай улс залуу хүн амтай орон хэвээрээ байна. Төрөх насны (15-49) эмэгтэйчүүд бүх хүн амын 26.2 хувийг эзэлж өнгөрсөн оноос 0.4 пунктээр өслөө. Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байгаа нь цаашид төрөлт өсөх нэг таатай нөхцөл юм.

Зураг 1.




1997 оны эхний хүн амын нас, хүйсний бүтцийг 1989 онтой харьцуулан суврагаар харуулав. 1989 онтой харьцуулбал суврагын суурь маш багассан нь төрөлт 1996 онд нэлээд буурсныг (29.6 хувиар) харуулж байна. Гэсэн хэдий ч 1980-аад онд төрөлтийн түвшин өндөр байсан нь нийт хүн амд 5-10 насны хүүхдүүдийн эзлэх хувь энэ хугацаанд нэмэгдэхэд хүргэлээ. 1996 онд 30-45 насанд суврага өргөссөн нь 1989 оны 21-36 насны хүмүүсийн нас баралт дараагийн жилүүдэд харьцангуй бага байсантай холбоотой юм. 1996 онд хүйсийн харьцаа 98.6 байгаа нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа зохистой байна. Хүйсийн харьцааны зохистой байдал нь гэрлэлтэнд эерэгээр нөлөөлсөн. Хүйсийн харьцаа нас ахих тусам багасч 70-аас дээш насанд 69.5 болсон байна. Энэ нь өндөр настай эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин харьцангуй өндөр байгаатай холбоотой.



1996 оны байдлаар манайд ажил хийж байгаа 1 хүн өөрөөсөө гадна 2 хүнийг тэжээж байна. (зураг 2) Харин хөдөлмөрийн насны

100 хүнд ногдох тэжээлгэгчийн (15 хүртэлх + 65-аас дээш) хэмжээ 69.7 байна. (хүн ам зүйн ачаалал)

Зураг 2.



Нийт хүн амд 65 түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийг дэлхийн зарим улс орнуудтай харьцуулахад манай орон залуу хүн амтай орон гэдэг нь харагдаж байна. (зураг 3)

Зураг 3.

Нийт хүн амд 65 түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийг дэлхийн зарим орнуудаар үзүүлбэл, 1996, 2020 оны байдлаар

1995 2020



(2020 оны урьдчилсан тооцоо)

Энэтхэг	4.59	8.10
Бразил	5.24	9.21
Солонгос	5.61	11.45
Хятад	6.11	10.51
Австрали	11.63	15.68
АНУ	12.65	16.13
Япон	14.13	25.16
Герман	15.22	20.88
Англи	15.46	17.96
Швед	7.31	20.72
Монгол	3.81	4.01

Мөн нэг км² нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 1.5 байгаа нь хүн амын нягтрал хамгийн багатай орны тоонд орж байна. Хүн амын нягтрал өмнө болон зүүн бүсэд сийрэг, төвийн бүсэд өндөр байна. Энэ


нь дэд бүтцийн хөгжил муу, ажиллах хүчний хэрэгцээ бага зэрэгтэй холбоотой.

Хүн амын нягтрал	Аймаг, хотын нэр
0.3-1.0	Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий
1.0-1.5	Булган, Завхан, Төв, Ховд, Хөвсгөл
1.5-2.0	Архангай, Өвөрхангай, Увс
2.0-10.0	Баян-Өлгий, Говьсүмбэр, Сэлэнгэ
10.0+	Орхон, Дархан-Уул, Улаанбаатар

Төрөлт


1996 онд 51.8 мянган хүүхэд төрсний 50.3 хувь нь хөвгүүд, 49.7 хувь нь охид байна. Энэ онд төрсөн хүүхдийн тоо өнгөрсөн оныхоос 4.6 хувиар буурчээ. Төрөлтийн үеийн хүйсийн харьцаа 100 охидод 101 хөвгүүд ногдож байна. 1000 хүн амд ногдох төрөлт 1.4 пунктээр буурч, 22.2 болов. Төрөлтийн түвшин 20-24, 25-29 насанд хамгийн өндөр, олон жилийн динамикаар ч гэсэн энэ насны бүлгүүдийн төрөлт өндөр болох нь зураг 4,5-аас харагдаж байна.

Зураг 4.




Төрөлтийн коэффициентийг насны бүлэг тус бүрт тооцсоноор янз бүрийн насны бүлгийн төрөлтийн түвшинг судлах боломжтой. 1996 оны эдсийн байдлаар насны бүлэг дэхь төрөлтийн түвшинг тооцож үзүүлэв. (зураг 5) Манайд 20-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт бусад насны эмэгтэйчүүдийг бодвол өндөр байна.

Зураг 5.



Өнгөрсөн онтой харьцуулбал 15-19 насны 1000 хүнд ногдох төрөлт 2.42 пунктээр, 20-24 насных 19.52 пунктээр, 25-29 насных 2.31 пунктээр, 30-34 насных 3.93 пунктээр, 35-39 насных 4.68 пунктээр, 40-44 насных 3.93 пунктээр, 45-49 насных 1.8 пунктээр тус тус буурсан нь төрөлт ерөнхийдөө өмнөх оноос буурсныг харуулж байна. Төрөх насны эмэгтэйчүүдийн дотроос 20-24 насны эмэгтэйчүүдийн 1000 хүнд ногдох төрөлт өмнөх оныхоос 19.5 пунктээр (бусад насны бүлгээс хамгийн ихээр) бага байгаа нь төрөлтийг бууруулахад голчлон нөлөөлөв. Төрөлтийн нийлбэр коэффициентийг харуулсан зураг 6-аас үзвэл нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 1980 онд 6.4, 1985 онд 5.5, байснаа 1990-ээд онд буурч 1996 онд 2.5 болсон байна. Үүнээс үзэхэд эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн хямралтай байдлаас болж мөн тэдний боловсрол болон нийгэмд эзлэх байр суурь өссөнтэй холбогдож цөөхөн хүүхэд төрүүлэх сонирхолтой болсон байна. (зураг 6)

Зураг 6.



Төрөлтийн бууралтанд амьжиргааны түвшин, ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшин, байр орон сууц хүрэлцээ хангамжгүй байдал, эрүүл мэндийн байдал, жирэмснээс урьдчилан сэргийлэх хэрэгслийн хэрэглээ, үр хөндөлт зэрэг нь нөлөөлсөн. Үр хөндөлтийг


амьсгалын замын өвчин	41.2 %
перинаталь үед болсон	24.8 %
хоол боловсруулах эрхтний	7.8 %
халдварт паразит	6.2 %
цусны эргэлтийн систем	5.2 %
мэдрэлийн систем, мэдрэх	4.6 %

Нас баралт нь улсын дунджаас (7.5) өндөр байгаа эхний 10 аймгуудыг жагсаавал:

I. Дорнод	8.8	VI. Увс	7.8
II. Говьсүмбэр	8.6	VII. Хөвсгөл	7.8
III. Хэнтий	8.4	VIII. Дорноговь	7.6
IV. Баянхонгор	8.2	IX. Өвөрхангай	7.6
V. Дундговь	8.2	X. Өмнөговь	7.6

Нас баралтыг нас барсан шалтгаанаар авч үзвэл осол гэмтэл болон өвчнөөр нас барагсдын тоо өсч байна. (Эрүүл Мэнд Удирдлага, мэдээллийн төвийн 1996 оны мэдээнээс авав) Зураг 11.


Зураг 10



Гэрлэлт, гэр бүл цуцлалт

1996 онд 14.2 мянган гэр бүл гэрлэлтээ бүртгүүлж, 908 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 1000 хүнд ногдох гэрлэлт 6.1, цуцлалт 0.4 байна. 18, түүнээс дээш насны 1000 хүнд ногдох гэрлэлт 10.9, цуцлалт 0.7 болжээ. Гэрлэлт өнгөрсөн оноос 6.1 хувиар буурч, цуцлалт 0.8 хувиар өссөн байна. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүмүүсийг нас, хүйсээр авч үзвэл нийт гэрлэсэн эрэгтэйчүүдийн 44.2 хувь нь 20-24 насных, 32.2 хувь нь 25-29 насных байгаа нь бусад насны бүлгийнхээс өндөр, 20-29 насанд гэр бүл болох нь их байна. Эмэгтэйчүүдийн хувьд мөн адил 51.3 хувь нь 20-24 насандаа, 23.8 хувь нь 25-29 насандаа гэр бүл болж байна. Манайд хүйсийн харьцаа зохистой байгаа нь гэрлэлтэнд эерэгээр нөлөөлж байна. (зураг 12)

Зураг 11.



Гэрлэлтээ бүртгүүлэгчдийн 44.3 хувь нь 1996 онд, 55.7 хувь нь 1996 оноос өмнө гэр бүл болж амьдарч байснаа 1996 онд гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Эдгээр гэр бүлээ хожуу бүртгүүлэгчдийн 48.7 хувь нь нэг жилийн өмнө, 33.4 хувь нь 2-3 жилийн өмнө, 18.0 хувь нь 4 ба түүнээс дээш жилийн өмнө гэр бүл бологсод байна. Манай орны хувьд гэр бүл болоод 1-3 жилийн дараа бүртгүүлэх нь давамгайлж байдаг бөгөөд энэ нь хүүхэд төрүүлснхээ дараа гэрлэлтээ батлуулах шаардлага гардагтай холбоотой.

Гэр бүл цуцлуулагчдын 89.0 хувь нь хотод, 11.0 хувь нь хөдөөд байгаа нь хотын хүн амын өсөлт болон амьжиргааны түвшинтэй холбоотой. Гэр бүлээ цуцлуулагсдыг нэг гэр бүлд амьдарсан хугацааг авч үзвэл:

Гэр бүл байсан хугацаа (жил)	1994	1995	1996
1 хүртэл	11.35	4.44	6.3
1-3	25.44	16.87	19.1
4-6	22.71	28.30	23.7
7-9	19.02	24.53	21.1
10-14	17.10	18.09	14.3
15-19	3.42	5.22	1.9
20+	0.96	2.55	4.7
Бүгд	100.0	100.0	100.0

Гэр бүл байсан хугацаагаар нь цуцлалтыг авч үзэхэд 4-9 жил хамт амьдарсан хүмүүсийн гэр бүл цуцлалт бусдаас өндөр байна.